

**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ,  
ИНЖЕНЕРИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ  
ХЭСЭГЧЛЭН ТҮРЭЭСЛҮҮЛЭХ ЖУРАМ**

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

- 1.1 Монгол улсын нутаг дэвсгэрт харилцаа холбооны нийтийн болон өртөг нэмэгдүүлэх үйлчилгээ эрхлэгчид нь харилцаа холбооны сүлжээ, инженерийн барилга байгууламж, байр талбайг хэсэгчлэн түрээслүүлэх үед үүсэх харилцааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2 Энэхүү журмыг мөрдөхдөө Монгол Улсын Харилцаа холбооны тухай хууль, Цахилгаан холбооны сүлжээнд холбогдох, сүлжээ хоорондын харилцан холболтын ерөнхий журам (цаашид ерөнхий журам гэнэ) болон Харилцаа холбооны салбарт мөрдөгдөж буй Монгол Улсын үндэсний стандартуудыг мөрдлөг болгоно.
- 1.3 Энэхүү журамд Монгол Улсын Харилцаа холбооны тухай хуулинд болон Ерөнхий журамд зааснаас бусад дараахи нэр томъёоны тодорхойлолтыг хэрэглэнэ.
  - 1.3.1 “Сүлжээний хэсэг” гэж төлбөр тооцоог тусад нь тооцох боломжтой сүлжээний техник төхөөрөмж, холбох шугам, суваг, хэрэглэгчийн шугамыг ойлгоно.

**ХОЁР. ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ**

- 2.1 Сүлжээ эзэмшигч нь өөрийн эзэмшлийн сүлжээ, инженерийн барилга байгууламж, байр талбайг бусад харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдэд хэсэгчлэн түрээслүүлэх эрхтэй.
- 2.2 Сүлжээ эзэмшигч нь нөөц гэж тодорхойлсноос бусад өөрийн эзэмшлийн сүлжээ, инженерийн барилга байгууламж, байр талбайг бусад харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдэд давамгайл байдлаа ашиглан хэсэгчлэн түрээслүүлэхээ татгалзах эрхгүй.
  - 2.2.1 Сүлжээ эзэмшигч нь Монгол улсын Харилцаа холбооны тухай хуулийн 23.1-д заасны дагуу өөрийн сүлжээ, инженерийн барилга байгууламж, байр талбайн нөөцийг ашиглуулна.
- 2.3 Сүлжээ эзэмшигч нь сүлжээ, инженерийн барилга байгууламж, байр талбайг хэсэгчлэн түрээслүүлэх техникийн нөхцөл шаардлага, үнэ тариф, гэрээ хийх үйл явцын талаархи мэдээллийг бусдад нээлттэй байлгаж, хэвлэн нийтэлнэ.
- 2.4 Сүлжээ эзэмшигч нь сүлжээ, инженерийн барилга байгууламж, байр талбайг бусдад хэсэгчлэн түрээслүүлэхдээ ялгаваргүй ижил нөхцлөөр хандах, эхэнд нь хүсэлт гаргасанд эхэлж үйлчлэх зарчмыг баримтална.

2.5 Сүлжээ эзэмшигч нь өөрийн сүлжээний хэсэг, инженерийн барилга байгууламж, байр талбайн байршил, багтаамжийн талаархи мэдээллийг Зохицуулах хороо болон хүсэлт гаргасан талд гаргаж өгнө.

## ГУРАВ. ТҮРЭЭСЛЭЖ БОЛОХ ЦАХИЛГААН ХОЛБООНЫ СҮЛЖЭЭНИЙ ХЭСЭГ БОЛОН ҮЙЛЧИЛГЭЭ

### 3.1 Техник төхөөрөмж

- Нягтруулгын төхөөрөмж
- Сүлжээний интерфэйсийн төхөөрөмж
- Холболтын байгууламж дахь хэрэглэгчийн модуль (Нэгдмэл Үйлчилгээтэй Тоон Сүлжээний, таксафоны)
- бусад

### 3.2 Холбох шугам, суваг, кабель

- Шилэн кабель, шилэн кабелийн шөрмөс
- Зэс кабель
- Тоон болон аналог суваг
- бусад

### 3.3 Хэрэглэгчийн шугам (Local loop)

- Бүрэн буюу холболтын байгууламж дахь кроссоос хэрэглэгчийн оруулга хүртэлх хэсэг
- Хэсэгчлэн буюу холболтын байгууламж дахь кроссоос гол, салбар кабелийн залгаа цэг хүртэл эсвэл гол, салбар кабелийн залгаа цэгээс хэрэглэгчийн оруулга хүртэлх хэсэг
- Өндөр давтамжийн зурвас буюу xDSL үйлчилгээний зориулалтаар ашиглах шугам

(Хавсралт зургаар харуулав.)

### 3.4 Үйлчилгээ

#### 3.4.1 Төлбөр тооцооны үйлчилгээ (Billing)

- Холболтын байгууламжид хэрэглэгчдийн яриа явагдсан тоолуурын мэдээлэлд үндэслэн төлбөр тооцох
- бусад

#### 3.4.2 Операторын үйлчилгээ

- Хэрэглэгчид төлбөрийн болон үйлчилгээний хугацааны талаар автомат эсвэл оператор хариулт өгөх
- Телефон дугаар лавлах үйлчилгээ
- бусад

#### 3.4.3 Шугам, кабелийн үйлчилгээ

- Хэрэглэгчийн шугамын гэмтлийн талаархи станцын мэдээлэл болон хэрэглэгчийн дуудлагаар шугам кабелийн засвар үйлчилгээ үзүүлэх
- Шинээр телефон утас тавих захиалгыг гүйцэтгэх
- бусад

## ДӨРӨВ. ИНЖЕНЕРИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ ТҮРЭЭСЛҮҮЛЭХ ТӨРЛҮҮД

- 4.1 Агаарын баганат шугам
- 4.2 Худаг, сувагчлал
- 4.3 Хуваарилах шүүгээ, хайрцаг
- 4.4 Цамхаг
- 4.5 Кросс буюу хэрэглэгчийн шугам хуваарилах зогсуур (MDF)
- 4.6 Холбох шугам хуваарилах зогсуур (DDF)
- 4.7 Эрчим хүч хангамжийн байгууламжууд (трансформатор)

#### ТАВ. БАЙР ТАЛБАЙГ АШИГЛУУЛАХ

- 5.1 Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгч нь сүлжээ хоорондын харилцан холболт, сүлжээнд холбогдоход шаардагдах тоног төхөөрөмжийг байршуулах зорилгоор бусад харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчийн байр талбайг түүн дэх зай тэжээлийн, агааржуулах болон гэмтэл дохиоллын төхөөрөмжийн хамт түрээслэн ашиглаж болно.
- 5.2 Түрээслүүлэгч нь өрөөнд байршуулсан төхөөрөмж болон өрөөний аюулгүй ажиллагааг хангахыг түрээслэгчид шаардах эрхтэй.

#### ЗУРГАА. ХҮСЭЛТ ГАРГАХ, ТҮҮНИЙГ ХҮЛЭЭН АВАХ, ШИЙДВЭРЛЭХ

- 6.1 Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгч нь сүлжээний хэсэг, инженерийн барилга байгууламж, байр талбайг түрээслэн ашиглах тухай хүсэлтээ сүлжээ эзэмшигчид бичгээр гаргана.
- 6.2 Хүсэлтийг сүлжээ эзэмшигч хүлээн авснаас хойш Ерөнхий журмын 4.2-т заасны дагуу ажлын 10 хоногт бичгээр хариу өгнө.
  - 6.2.1 Татгалзсан хариу өгсөн тохиолдолд хариу бичигтээ шалтгааныг тодорхой заана.
  - 6.2.2 Зөвшөөрсөн тохиолдолд хариу бичигтээ техник төхөөрөмжийг суурилуулах, холболт хийх, гэрээ байгуулах хугацааны талаар тусгах ба нийт хугацаа ажлын 60 хоногоос хэтрэхгүй байна.
  - 6.2.3 Сүлжээний хэсгийг түрээслэх тохиолдолд зааглах цэгийг талууд гэрээ байгуулахаас өмнө "Цахилгаан холбооны сүлжээнд холбогдох, сүлжээ хоорондын харилцан холболтын ерөнхий журам"-ын 6-р бүлэгт заасны дагуу тогтооно. /Энэ заалтыг 2006 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 10 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан./

#### ДОЛОО. ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

- 7.1 Сүлжээний хэсэг, инженерийн барилга байгууламж байр талбайг түрээслүүлэх үед талууд Ерөнхий журмын 9-д заасан Холболтын болон харилцан холболтын гэрээ байгуулах тухай холбогдох заалтуудыг дагаж мөрдөнө.
- 7.2 Түрээсийн гэрээг байгуулж, талууд гарын үсэг зурсан өдрөөс хойш 10 хоногийн дотор уг гэрээг зохицуулах хороонд бүртгүүлнэ. (Зөвхөн сүлжээ эзэмшигчтэй байгуулсан гэрээнд хамаарна.)

7.3 Сүлжээ эзэмшигч нь түрээслүүлж буй сүлжээний хэсэг, инженерийн барилга байгууламж, байр талбайн ашиглалт үйлчилгээг хариуцах ба сүлжээний бусад хэсэгтэйгээ ижил байлгах шаардлагыг хангаж ажиллана.

7.4 Түрээслүүлэгчийн инженерийн барилга байгууламж, байр талбайг ашиглан суурилуулсан түрээслэгчийн тоног төхөөрөмж, кабель шугамын ашиглалт үйлчилгээ болон аливаа хэмжилт, шалгалтыг хийх, тэдгээрийг гүйцэтгэх боломжоор хангах тухай хоёр тал харилцан тохиролцож гэрээндээ тусгана.

#### НАЙМ. ҮНЭ ТОГТООХ ЗАРЧИМ

8.1 Түрээслүүлэгч нь тухайн түрээслэж байгаа сүлжээний хэсэг, инженерийн барилга байгууламж, байр талбайн тодорхой хэсэгт ноогдох ашиглалтын болон хөрөнгийн эргэн төлөгдөх зардлыг нөхөхтэй холбогдсон шууд зардлуудыг тооцож түрээсийн үнийг тогтооно.

8.2 Түрээслүүлэгч нь өөрийн эзэмшлийн сүлжээ, инженерийн барилга байгууламж, байр талбайг хэсэгчлэн түрээслүүлэхдээ үнийн ялгаваргүй байдлыг хангах зарчмыг баримтална.

#### ЕС. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ БОЛОН ХАРИУЦЛАГЫН ТАЛААР

9.1 Маргааныг шийдвэрлэхдээ Зохицуулах хорооноос баталсан “ХХЗХ-ноос гомдол, маргааныг хүлээн авах, хянах, шийдвэрлэх журам”-ыг мөрдлөг болгоно.

9.2 Ерөнхий журмын Маргаан шийдвэрлэх, Хариуцлагын талаархи 10, 11-ийн заалтуудыг дагаж мөрдөнө.


*/Энэ журамд 2006 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 10 дугаар тогтоолоор оруулсан нэмэлт, өөрчлөлтийг тусгасан./*

----- о О о -----



# ХАВСРАЛТ

## Хэрэглэгчийн шугамыг хэсэгчлэн түрээслүүлэх хэлбэрүүд

### 1. Бүрэн (Full unbundling – Local loop)



### 2. Хэсэгчлэн (Subloop)



3. Өндөр давтамжийн хэсэг (High frequency portion of the loop or shared use of local loop)

